



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн нээлттэй дуудлагын  
худалдааг дахин зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн Ерөнхий зөвлөлийн харьяа Баянгол, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан автомашины 3 дахь дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2. Автомашины худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

3. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, Баянгол, Хан-уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Н.Батхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


3.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

3.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000281

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2019 оны 05 дугаар сарын 07 ны өдрийн  
 145 дугаар тогтоолын хавсралт

6098169 1118262983

**НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДАГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Явсан км	Балансын үнэ	Үлдэх өртөг	ТӨХ-ны 2018 оны 492 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ	Шинэчлэн тогтоосон үнэ
(төгрөг)							
Баянгол, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын балансад бүртгэлтэй автомашин							
1	Суудлын автомашин, Исузу Визард, 03-57 УНУ, арал UES73FW4104053	1998/2007	154,831.00	12,210,000.00	0	1,500,000.00	750,000.00
<b>НИЙТ ДҮН</b>				<b>12,210,000.00</b>	<b>0</b>	<b>1,500,000.00</b>	<b>750,000.00</b>
				(арван хоёр сая хоёр зуун арван мянган)		(нэг сая таван зуун мянган)	(долоон зуун тавин мянга)